



Нэр томьёоны орчуулгын асуудалд (Барилгын материалын нэр томьёоны жишээгээр)

С.Дугармаа* (ШУТИС)

Хураангуй: Нэр томьёог орчуулан хэрэглэх шаардлага аль ч салбарт гарч байна. Бид сүүлийн жилд эрчимтэй хөгжиж байгаа барилгын материалын салбарын нэр томьёог жишээ болгон авч нэр томьёоны орчуулгын талаар бичлээ. Барилгын салбарын нэр томьёог монгол хэлний дүрэмд зохицуулан жигдлэх асуудлыг анхаарах нь чухал болохыг хөндөн бичсэн юм. ШУТИС-ийн барилгын материал судлалын судлаач эрдэмтдийн бичсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, ном сурах бичиг, толь бичиг мөн олон нийтийн хэрэгцээнд хэвлэн гаргадаг “Барилга МН” сэтгүүл зэргээс түүвэрлэсэн жишээ баримтанд тулгуурлан бичлээ.

Түлхүүр үг: мэргэжлийн хэрэглээ, толь бичиг, хэлний онцлог, ухагдахуун

Хэлний тогтолцоог бүрдүүлж буй нэгжүүдийн нэг бол нэр томьёо юм. “Нэр томьёо нь хүний мэдлэгийн тодорхой салбарын ухагдахууны тогтолцоон дахь аль нэг ухагдахуунтай холбоотой тийм үг, хэлний тэмдэг юм. Үг нэр томьёо болохдоо хэрэглэгдэх нь багасаж, гагцхүү тухайлсан сэдэвт тусгай нэгэн утгаар орох болдог.” (Л.Болд “Монгол хэл шинжлэлийн асуудалд” 2006 он.)

Европын аль нэг хэлнээс нэр томьёог голдуу орос хэлээр дамжуулан тухайн нэр томьёог урьд өмнө толь бичигт хэрхэн орчуулсныг хайхралгүйгээр галигчлан авч хэрэглэснээр монгол хэлэнд гадаад үг олноороо орж ирж байна.

Нэр томьёог зөв тогтоох, тэдгээрийн нарийн тогтолцоог гаргах, нэг мөр болгох, жигдлэх асуудал нэр томьёо судлаачид болон нэр томьёог хэрэглэж буй мэргэжлийн салбарын мэргэжилтнүүдийн анхаарлыг татсаар ирсэн. 1925 онд улсын нэр томьёоны комисс байгуулагдаж, шинжлэх ухаан техникийн нэр томьёог тогтоох, батлах, мэдээлэх ажлыг эрхлэн хариуцаж байсан билээ.

Хэлбичгийн эрдэмтэн судлаачид, салбарын мэргэжлийнхэнтэй хамтран нэр томьёог боловсруулан нэр томьёоны толь бичиг, улсын нэр томьёоны комиссын (УНТК) мэдээ, нэр томьёоны сэдэвчилсэн толь, нэр томьёоны нэгдсэн тольд хэвлэн мэдээлж олны хүртээл болгож байсан. Үүнд УНТК-ийн мэдээ 1957-1980 онд 124-ийг, нэр

*ШУТИС-ийн ХБС-ийн Англи хэл судлалын багийн тэргүүлэх профессор, доктор

томъёоны сэдэвчилсэн толь 30 орчмыг нэр томъёоны нэгдсэн толь 3-ыг хэвлэн гаргажээ. Энэ хугацаанд барилгын нэр томъёоны УНТК-ийн мэдээ 1954, 1958 онд гарсан байна. Барилгын материалын салбарт хэрэглэж ирсэн толь бичгүүд: "Dictionary of Civil Engineering in Twelve Languages" (Bulgarian, Czech, German, Hungarian, Mongolian, Polish, Rumanian, Russian, Serbo-Croatian, Spanish, English and French) 1979, 28000 terms, Moscow, Russian Language Publishers, Р.Санжаасүрэн, Э.Нордов, С.Жамъянсүрэн "Англи-Монгол толь /Цемент, бетоны хими, технологи/", English-Mongolian Dictionary/Chemistry and Technology of Cement and Concrete/ edited by Ts.Erdenebat 2007 (19.000 entries), З.Биндэрьяа, Т.Долгоржав, Б.Оюун "Барилгын мэргэжлийн хэлний хураангуй толь" / Монгол-орос-англи, Англи-монгол-орос, Орос –англи-монгол /2004 он, 1400 гаруй үгтэй, Англи-оросхэлний барилгын нэр томъёоны онлайн толь www.zodchii.ws/terms/info-2.html зэрэг олон толь бичиг ашиглагдаж байна.

Нэр томъёо бүр цаанаа шинжлэх ухааны тодорхойлолттой байдгаараа мэргэжлийн үгээс ялгаатай. Жирийн үг нэр томъёо болох шалгуур нь үгийн утга нь ухагдахуунтайгаа дүйж, шинжлэх ухаан техникийн нарийн ухагдахууныг илэрхийлж чадаж уу гэдгээр нь тодорхойлолдог байна. Мэргэжлийн үг нь үгийн сангийн судлагдахуун болж байдаг бол нэр томъёо нь үгийн сан судлалын тусгай салбар болох нэр томъёо судлалын судлагдахуун болж байна. Нэр томъёог нэгдсэн бодлогоор оноон тогтоож, жигдэлж хэвшүүлдэг бол мэргэжлийн үг, нийгмийн харилцааны явцад үгийн сан баяждагтай адил аясаараа хөгжин баяжих онцлогтой юм. Нэр томъёо нь дараах шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:

1. Нэр томъёо нь тогтолцоотой байх.
2. Шинжлэх ухааны тодорхой салбарт үйлчилдэг байх
3. Нэр томъёо нь ухагдахуунаа оновчтой илэрхийлэх
4. Нэр томъёо ерөнхийдөө нэг утгатай байх
5. Нэр томъёо бүр учирзүйн уялдаа холбоо бүхий шинжлэх ухаанч тодорхойлолттой байх
6. Сэтгэл хөдлөлийн өнгө аясгүй байх
7. Нэр томъёо аль болох товч байх
8. Ойролцоо утгат үггүй байх
9. Тухайн хэлний үг бүтэх үүднээс зөв байх
10. Хос нэр томъёогүй байх

Нэр томъёоны хос нэршлийг нэр томъёо болгон хэрэглэх тухай судлаачид харилцан адилгүй саналтай байдаг ч зөрөөтэй нэр ойролцоо нэр томъёо байж болохгүй талаар нэгдмэлбодолтой байдаг. Барилгын нэр томъёонд: асфальт –барагшин, замын хар, царгай, асфальтит-цардас, барагшил, балка-гулдан, гулдмай, дамнуур, дам нуруу гэх мэтээр нэр томъёог оноон бичсэн нь хос (дублет) биш ойролцоо утгыг агуулж байгаа юм. Харин орлох нэр нь шинжлэх ухааны нэг ухагдахууныг өөр өөр үгээр нэрлэдгээрээ ойролцоо нэрээс ялгардаг. Иймээс барагшин-замын хар-царгай, цардас-барагшил, гулдан-гулдмай-дамнуур-дам нуруу зэрэг нь ойролцоо нэр томъёо болж байна. Нэр томъёо, мэргэжлийн үг хэллэг шинжлэх ухаан техникийн зохиол бүтээлийг орчуулахад багагүй үүрэг гүйцэтгэдэг. Нэр томъёог буруу орчуулснаас эх зохиолын утгыг буруу гаргахад хүргэдэг.

Ихэнх нэр томъёо нь дүйх монгол нэр томъёотойгоо тохирч байдаг. Жишээ нь: rock-хайрга, block-гулдмай, wood-мод, oil paint-тосон будаг, glue-цавуу, mortar-зуурмаг, nail- хадаас, brick-тоосго гэх мэт.

Тайлбарлан орчуулах тохиолдол бас байна. Энэ нь шинэ ойлголт ухагдахууныг нэрлэсэн нэртомъёо нь хэвшээгүйтэй холбоотой. Жишээ нь: Ruberoid-дээврийн хуйлмал материал, pigment- хуурай будаг, emulsion-усан будаг, pitch-давирхайн нэрлэгийн үлдэгдэл, gore-томсон төмөр утас, dabideon-гөлтгөнө ба жижиг чулуулагийн зуурмаг (дотор өнгөлгөөнд зориулсан), gravel-голын эргийн хайрга гэх мэт.

Галигчлан орчуулах нь олон тохиолдох болсныг дараах жишээ баримтаас харж болно. Жишээ нь: cement-цемент, brique-брикет, ceramic-керамик, bitumen-битум, asphalt-асфальт, parquet-паркет, plinth-плинтус

Орчуулан хэрэглэхдээ монгол хэлний үгийн зөв бүтцийг анхааран орчуулах нь зүйтэй байна. Үүнд: Язгуур+ дагавар+нөхцөл

1) Язгуурын утгыг мэдэх /Гэ, ГЭГ, ЭгЭ/

2) Дагаврын утгыг мэдэх

3) Нөхцөлийн утгыг мэдэх

Барилгын салбарын нэртомъёоны хувьд үйл үндсэнд залгаж нэр үг бүтээдэг

- лага/-лэг, -лого, -лөг/, -лаг/-лэг, -лог,-лөг/, -лга/-лго, -лгэ, -лгө/ - хавчуулга-вкладыш-insert, хучлага-pavement (surfacing), чулуулаг- rock, шаварлаг-marsh, түрхлэг-creme -гч дүүргэгч-aggregate, бүлэгнүүлэгч-коагулянт-coagulant, барьцалдуулагч-вяжущее вещество-binder, тусгаарлагч-изоляционный материал, insulation material-лт, хучилт-covering, зууралт-clutch, зүсэлт chopping, cut-уур, -үүр, тосгуур-раковина-sink, тулгуур-опора-support abutment зэрэг нэр үг бүтээх дагавар хамгийн идэвхтэй хэрэглэгдэж байна.

Тухайн мэргэжлийн олон нийтэд тархсан олон улсын чанартай үг хэллэг нэр томъёог заавал орчуулан хэрэглэх нь нэг талаас тухайн ойлголтыг будлиантуулах муу талтай.

Шинжлэх ухаан болон шинжлэх ухаан, техникийн холбогдолтой сэдвүүдийг орчуулахдаа голдуу цаад орчуулж байгаа хэлэнд бэлэн байгаа нэр томъёог юуны өмнө ашигладаг. Шинжлэх ухааны зарим нэр томъёо орчуулж буй хэлэнд нь дүйх нэр томъёо байхгүй эсвэл даруй зохион оноож боломгүй бол орчуулагч л уг асуудлыг шийдэх болдог бөгөөд түүний хэлбичгийн боловсрол, үгийн язгуурын холбоог аль хэр мэдэх, хам сэдвээр нь нэр томъёоны бололцоот утгыг олж тавих чадвар чухал үүрэгтэй.

Нэр томъёог орчуулахдаа цаад гадаад хэлний нэр томъёоны утга санаанд тохирох үгийг эх хэлнээсээ оноох уу, гадаад үг зээлдэх үү гэдгийг зөв шийдэх ёстой. Монгол хэлний дуудах ёсноос бага зэрэг гажиж байгаа гадаад үгийг хэлнийхээ хэм хэмжээнд тааруулан бага зэрэг өөрчлөн зээлж хэрэглэдэг. Жишээ нь: emulsion-эмулсион-эмүүлс, саутчос-каучук-кавчук, tile-черепиц-шифр, putty-замаск-замаасар, putty knife-шпаклеватель-шпатель

Мөн гадаад үгийг монгол хэлний бичих ёсноос гажиж байгаа тохиолдолд монгол хэлний зүй тогтолд нийцүүлэн бичдэг. Жишээ нь: argillite-аргилит, brique-брикет, pearlite-перлит,

Зарим тохиолдолд монгол хэлэнд байж боломгүй үг үүсгэн хэрэглэж байгааг анхаарах нь зүйтэй. Тухайлбал: нэвтэршил, хувьшил, ажилбар, багтаамшил, хөөсөнцөр, чихтэс, тулааз, барзайлгалт, дулаан шингээвч, зөөллүүр гэх мэт.

Д.Дашжамц, Б.Батцагаан, Б.Мандах “Монгол улсын барилга хот байгуулалтын салбарын өнөөгийн байдал, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн бодлогын зарим асуудалд” 2009 он, өгүүллэгт сүүлийн үед барилгын материалын үндэсний үйлдвэрлэл сэргэж, шинэ нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл нэмэгдэж байна гээд арван таван бүтээгдэхүүнийг нэрлэн бичсэн байна. Үүний доорх ес нь нэр томъёог орчуулан зарим хэсгийг нь галигчлан зарим хэсгийг орчуулсан байна. Үүнд: Арматурчлагдсан сэндвичэн хавтан, хөөсөн перлитийн элс, автоклавын бус газобетон, полистрол бетон, алевролитын хөнгөн дүүргэгч, пеноизол, магнийн цементэн ханын хөнгөн хавтан, сантехникийн хуванцар ба бетон хоолой, өндөр даралтын усны полимер хоолой зэрэг

Эдгээрээс заримыг нь ч болов монгол хэлнээ дүйх үг байсаар байтал галигчлан бичжээ. Жишээ нь: газобетон-хийт бетон, полимер- хуванцар, цементэн- барьцалдуулагч

Гадаад нэр томъёо нь монгол хэлний үгнээс өөрцгүй ойлгомжтой болсон үгс олон байдаг. Жишээ нь: охор-ochre, цемент-cement, блок-block, гипсэн хавтан-gypsum plate, эмульс (цийдмэг)-emulsion, брикет (шахмал)-brique, керамик (вааран, шавар)-ceramic, битум (хар тос, цардас)-bitumen, асфальт (цардмал)-asphalt, паркет (зүймэл шал)-parquet, обой гэх мэт. Нөгөөтэйгүүр зарим гадаад нэр томъёо монгол хэлэнд ойролцоо утгатай нэр томъёотой авч, цаад ухагдахууныхаа утгыг нарийвчлан гаргах нь дээр буюу эсвэл монголоор олон үгээр буудаг зэргээс гадаад үгээр нь буулгадаг. Жишээ нь: siding- сайдинг (дээврийн хуйлмал материал), pitch-питч, (давирхайн нэрлэгийн үлдэгдэл)

Эх хэлэнд бэлэн үг, нэр томъёо байгаад гадаад нэр томъёо нь төдийлөн нийтэд ойлгомжгүй бол гадаад үг хэрэглэх шаардлагагүй нь мэдээж. Эсвэл нарийн мэргэжлийн цөөн хүмүүст л ойлгомжтой (каолин, ферроцемент) нийтэд ойлгомжгүй бол мөн нэгэн адил анхаарвал зохино. Ийм тохиолдолд олон нийтэд ойлгомжтой болгохын тулд орчуулан хэрэглэх нь зүйтэй. Мөн барилгын материалын товчилсон нэрийг хэдийгээр монгол хэлээр нэрлэх боломжтой ч тэр чигээр нь хэрэглэх нь элбэг байна. Жишээ нь: ДСП-древесно слоистые пластики-үртсэн хавтан, OSB panel-Oriented Standard Board-ориентированно- стружечная плита-зоргодсон хавтан, PVC siding-polevinyl chloride

“Барилга МН” сэтгүүлийн 2012 оны (9 сар) №28 -д барилгын материалын зар сурталчилгаанд PVC siding, OSB панель, хөнгөн цагаан давхаргаатай PAP хоолой гэх мэтээр англи, монголоор холин бичсэн байна. Мөн тус сэтгүүлийн 2012 оны (12 сар) №31-д “JOB1 барилгын материалын дэлгүүр шинэ жилийн урамшуулалттай худалдаа Солонгос эмульс, обой 15-32% off, гипсэн хавтан, өнгө оруулагч пигмент” гэх мэт бичсэнийг хэрэглэгчдэд ойлгомжтой галигчлан ба тайлбарлан орчуулан хэрэглэх нь зохистой гэж бодож байна.

Салбарын мэргэжилтэнд зориулсан эрдэм шинжилгээний зохиолд гадаад нэр томъёог орчуулгагүй хэрэглэх бол нийтэд зориулж байгаа үедээ (шинжлэх ухааны хялбарчилсан ном зохиол, ярианд) голдуу орчуулж хэрэглэдэг.

ШУТИС-ийн Барилгын инженер, архитектурын сургуулийн оюутанд зориулан профессор Б.Батцагааны 2010 онд хэвлүүлсэн “Барилгын материал” сурах бичигт полимир, керамик, органик, ситалл, дегт, автоклав, карьер, силикат, картон, синтетик, перлит, битум, казеин, пластмасс, полиэтилен, полистриол, линолеум зэрэг олон гадаад нэр орсон нь цаашид анхааран орчуулан хэрэглээнд оруулж хэвшүүлэхийг анхаарах ёстой.

Сурах бичгийн хэл нь эрдэм шинжилгээний хэл найруулгын төрөлд багтдаг тул товч, тодорхой оновчтой, олон салаа утгагүй, учир шалтгааны дарааллыг нарийн гаргасан байхыг шаарддаг.

Гэхдээ нэр томъёо болгоныг орчуулах гэж дайраад монгол хэлээ олон улсын чанартай нэр томъёогоор баяжуулахгүй, гаднаас үг оруулахгүй гэж эх хэлээ тойруулж хана босгох шаардлагагүй юм.

Дүгнэлт

Нэр томъёог зөв тогтоох, тэдгээрийн нарийн тогтолцоог гаргах, нэг мөр болгох, жигдлэх асуудалд нэр томъёо судлаачид болон салбарын мэргэжилтнүүдийн оролцоо чухал байна.

Шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэх, хэрэглэх болсноор барилгын тэр дундаа барилгын материалын салбарт гадаад нэр томъёо хэрэглэх нь элбэг болжээ. Үүнийг орчуулах эсэхийг зориуд анхаарах хэрэгтэй.

Монгол хэлэнд бэлэн үг, нэр томъёо байгаад гадаад нэр томъёо нь төдийлөн олон нийтэд ойлгомжгүй бол гадаад үг хэрэглэх шаардлагагүй ба ойлгомжтой болгохын тулд орчуулан хэрэглэх ба ингэхдээ монгол хэлний үг бүтэх ёсны дагуу зохиоход анхаарах нь зүйтэй байна.

Ашигласан ном хэвлэл

1. Батцагаан Б. “Барилгын материал” 2010
2. “Барилга МН” сэтгүүлийн 2012оны (9 сар) №28, 2012 оны (12 сар) №31
3. Биндэръяа З., Долгоржав Т., Оюун Б. “Барилгын мэргэжлийн хэлний хураангуй толь” / Монгол-орос-англи, Англи-монгол-орос, Орос –англи-монгол /2004 он,
4. Болд Л. “Монгол хэл шинжлэлийн асуудалд” 2006 он
5. Дашжамц Д., Батцагаан Б., Мандах Б. “ Монгол улсынбарилга хот байгуулалтын салбарын өнөөгийн байдал, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн бодлогын зарим асуудалд” Шинжлэх ухаан, технологи -Монгол улсын хөгжил олон улсын эрдэм шинжилгээний хурал, УБ 2009 он
6. www.zodchii.ws/terms/info-2.html
7. <http://www.bolor-toli.com/>

Resume

Terminology translation is required for customers in applied sciences such as construction material study. In connection to the development a construction sector in Mongolia many construction materials have been produced and imported in recent years. Therefore we need to translate terms related to new construction materials and we have discussed how to use terms in this field.